

**БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
МУИХ-ЫН ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Н.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалтад заасны дагуу Улсын Их Хурал “хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах” онцгой бүрэн эрхтэй.

Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний стратегийн зорилт 2.1-т “Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны өнөөгийн арга хэлбэр, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, чадавхыг сайжруулах”, 2.2-т “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх байнгын тогтолцоог бүрдүүлж, чадавхжуулах” гэж, зорилтын 2.1.1-д “Парламентын хяналтыг Засгийн газрын үйл ажиллагаанд төвлөрүүлдэг нийтлэг зарчмыг баримталж, Засгийн газрын гишүүд болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын албан тушаалтанд Улсын Их Хурлын гишүүд асуулт, асуулга тавьж, албан ёсны хариуг хэлэлцдэг журмыг боловсронгуй болгох, чанар, үр нөлөөг дээшлүүлэх;” 2.1.4-т “Улсын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад тавих Улсын Их Хурлын хяналтын үйл ажиллагааг төгөлдөржүүлэх;”, 2.1.7-д “Улсын Их Хурлаас хийх хяналт шалгалтын ажилд төрийн хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах”, 2.2.4-т “Улсын Их Хурал, Байнгын болон бусад хороодоос байгуулагдан ажилладаг хянан шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, үйл ажиллагааны хүрээг тогтоож харилцан уялдаатай, үр нөлөө бүхий хяналтын механизм болгон төлөвшүүлэх;”, 2.2.5-т “Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд Улсын Их Хурал дахь цөөнхийн төлөөлөл, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгох;”, 2.2.6-т “Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийн хүрээнд төр, засгийн байгууллагуудаас ирүүлдэг хуулийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн болон бусад мэдээллийн чанар, шуурхай байдлыг сайжруулж, үр нөлөөг дээшлүүлэх;” гэж тус тус заасан.

“Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 44 дүгээр тогтоолын 2 дахь заалтад Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтэд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг нийцүүлэхээр заасан.

1.2.Практик хэрэгцээ шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санааны дагуу Монгол Улсын Их

Хурлын хяналт шалгалтын анхдагч хуулийг баталснаар Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагаа шинэ үе шатанд гарсан.

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс цахим хэлбэрээр асуулт тавьж, хариулт авах боломжийг бүрдүүлснээр Засгийн газрын мэдээллийн үр нэлөө дээшилсэн. 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд D.parliament.mn цахим системд Ерөнхий сайдын 4 мэдээллийг байршуулан Ерөнхий сайд мэдээллийн цагаар 23 иргэний 41 асуултад хариулт өгчээ. Засгийн газраас 6 удаа мэдээлэл хийж, 43 гишүүн 187 асуулт асууж, үг хэлжээ.

2022 онд 59 гишүүн 90 асуудлаар 40 асуулга тавьж, 9 асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар, 18 гишүүн 45 асуудлаар 18 асуулт тавьж, 1 асуултын хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцжээ. 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд УИХ-ын 6 гишүүн 64 асуудлаар 7 удаа асуулга тавьж, 2 асуулга нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн бол мөн хугацаанд 2 гишүүн 20 асуудлаар 4 удаа асуулт тавьжээ.

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр бодлого, төлөвлөлт тогтвортой байхаар зааж, түүнд нийцүүлэн хөгжлийн болон төсвийн бодлогын баримт бичгүүдийг харилцан уялдаатай төлөвлөлх хуулийн зарчим, шаардлагуудыг хуульчилсны дагуу бодлого төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналтын чанарт тодорхой ахиц гарч, түүнд Үндэсний аудитын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Төсвийн тогтвортой байдлын зөвлөл хяналт, шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмж гарган, Улсын Их Хурлын гишүүдийг мэдээллээр хангах ажиллагаа тогтмолжиж байна.

Мэдээлэл, тайлан, илтгэлийг сонсох ажиллагааг нарийвчлан зохицуулах болсноор хуульд заасан 13 байгууллагын мэдээлэл, тайлан, илтгэлээс 9 байгууллагын тайланд Улсын Их Хурлын Тамгын газраас шинжилгээ хийжээ. 2023 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Байнгын, дэд хороодын хуралдаанаар Засгийн газрын гишүүд болон бусад байгууллагын 14 удаагийн мэдээлэл, тайлан илтгэлийг хэлэлцсэн ба давхардсан тоогоор 112 гишүүн 335 асуулт асууж, үг хэлжээ. Хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр нэлөөг үнэлэх байнгын тогтолцоо бүрдэж эхэлж байна.

Эрх зүйн шинэ орчинд Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлын хэсгийн үйл ажиллагаа идэвхжин, 2022 оны байдлаар Улсын Их Хурал, Байнгын, дэд, түр хорооноос хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий нийт 36 ажлын хэсэгт (давхардсан тоогоор) 288 Улсын Их Хурлын гишүүн ажиллажээ.

2023 намрын ээлжит чуулганы хугацаанд хяналт шалгалтын 21 ажлын хэсэгт давхардсан тоогоор 123 гишүүн ажилласан. Ажлын хэсгийн 3-ыг УИХ-ын даргын захирамжаар, 17 нь Байнгын хорооны тогтоолоор, 1 нь дэд хорооны тогтоолоор байгуулсан ба эдгээрээс 4 ажлын хэсэг тайлангаа танилцуулж, үйл ажиллагаа дуусгавар болсон.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн сан байгуулах эрх зүйн орчин бүрдсэнээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлан, мэдээлэл авах, Улсын Их Хурлаас даалгасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах зэрэг Улсын Их Хурлын хяналтын бүхий л үйл ажиллагаа цахимжиж, олон нийт танилцах боломжийг бүрдүүлж байна.

Хяналтын сонсголыг зохион байгуулж, хянан шалгах үйл ажиллагаан дахь сонирхогч талуудын оролцоог нэмэгдүүлж, хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлсэн. Монгол Улсын Их Хурлаас 2020-2022 онд Ерөнхий хяналтын 2, нэр дэвшигчийн 9 сонсголыг зохион байгуулжээ.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, шинэчлэх нь тасралтгүй үргэлжлэх үйл явц юм.

Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа 800 гаруй хуулийн хэрэгжилт, үр нөлөө хангалтгүй байна. Улсын Их Хурал 2021 онд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль баталж, хуульд заасан 7 арга хэрэгслээр дамжуулан хяналт тавих бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа хэдий ч хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханглуулах чиглэлээр Засгийн газрын үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналт сул, хэрэгжилтийг хянан хэлэлцдэг байнгын шинжтэй тогтолцоо бий болоогүй байна. УИХ-ын 2023 оны хаврын ээлжит чуулган завсарлахад гаргасан статистик мэдээллээр Монгол Улсын Их Хурлаас Засгийн газарт үүрэг чиглэл болгосон Монгол Улсын 125 хуулийн 460 хэсэг, заалт, УИХ-ын 94 тогтоолын 444 заалт, Байнгын болон дэд, түр хорооны 86 тогтоолын 647 заалтыг хяналтад авч мэдээллийн санд бүртгэлтэй байна.

ЗГХЭГ-аас хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайлагналт хангалтгүй, тухайлбал 2022 оны жилийн эцсийн байдлаар УИХ-ын Тамгын газрын хяналтад байгаа нийт хууль тогтоомжийн дунджаар 43.3 хувийн хэрэгжилтийг ирүүлжээ.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11.3-т заасны дагуу үүрэг чиглэл өгсөн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх тайланг Засгийн газраас хагас жил тутамд УИХ-д ирүүлдэг хэдий ч Байнгын хороод хэлэлцдэггүй, хэзээ, хэрхэн хэлэлцэхийг хуульчлаагүй, тайлан нь зөвхөн үүрэг, чиглэл өгсөн заалтаар хязгаарладаг зэрэг нь хуулийн хэрэгжилтэд Улсын Их Хурал хяналт тавих үр нөлөөтэй арга механизм болж чадаагүй байна.

2019 оны Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайдын эрх хэмжээ нэмэгдсэнээр хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагын хяналт-тэнцлийг хангахад Засгийн газрын үйл ажиллагаанд тавих Улсын Их Хурлын хяналтыг нэмэгдүүлэх, авлига, ашиг сонирхол, хүнд суртлаас ангид, хариуцлагатай гүйцэтгэх засаглалыг бэхжүүлэхэд Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааг чиглүүлэх хяналтын арга хэрэгслийг боловсронгуй болгох шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

Улсын Их Хурлын гишүүний асуулт, асуулгын үр нөлөө хангалтгүй, түүнчлэн асуулт, асуулгын хариу шаардлага хангахгүй, хариуг нэгдсэн, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхийг гишүүний саналаар шийдвэрлэдэг зэрэг нь асуулга, асуултын ач холбогдлыг бууруулдаг. Асуулга, асуулт тавих ажиллагаан дахь гишүүдийн болон төрийн албан тушаалтны хариуцлагыг өндөржүүлэх, Байнгын хороогоор хэлэлцэж, мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгох, шаардлагатай гэж үзвэл нэгдсэн чуулганаар хэлэлцүүлдэг байхаар эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай.

Нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд хүндэтгэн үзэх шалтгаантай ирэх боломжгүй бол Ерөнхий сайдын мэдээллийг түүний томилсон Засгийн газрын гишүүн хийх өөрчлөлт оруулснаар бодлогын асуудлаар Улсын Их Хурлын гишүүд, цөөнхийн төлөөлөл хангалттай бүрэн мэдээлэл авахгүй, мэдээллийн үр нөлөөг

бууруулж байна. Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах нь цөөнхийн төлөөллийн хяналтын чухал арга хэрэгсэл байдаг. Түүнчлэн Ерөнхий сайдын хийх мэдээллийг 14 хоног тутамд сонсох зохицуулалтыг сардаа нэг удаа болгон бодлогын шинжтэй асуудлаар хэлэлцүүлгийг явуулах, мэдээллийн цагийн үргэлжлэх хугацааг 1 цаг 30 минутад багтаах, хариулагдаагүй асуултыг бичгээр авч цахим системд байршуулах байдлаар Ерөнхий сайдын мэдээллийн хэлэлцүүлгийн чанар, үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлага үүсч байна.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын үйл ажиллагааны төлөвлөлт сул, Улсын Их Хурлын даргын захирамжаар баталдаг хяналт, шалгалтын цаглаврын хэрэгжилт хангалтгүй байна. 2022, 2023 оны Улсын Их Хурлын ээлжит З чуулганы хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалтын цаглаварт дунджаар 58 асуудлыг төлөвлөсөнөөс 24.1 хувь нь хэрэгжсэн, 39.6 хувь нь хэрэгжих шатандаа, 36.3 хувь нь хэрэгжээгүй.

Бодлого төлөвлөлт, төсөвлөлт, тайлагналтад тодорхой ахиц дэвшил байгаа хэдий ч тавигдаж буй шаардлагын түвшинд хүрэхгүй байна. Бодлогын баримт бичгийн хоорондын уялдаа хэрхэн хангагдсан талаар тайлагнадаггүй, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт тодорхой биш, зорилго, зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дутуу тайлагнадаг, түүний шалтгаан нөхцөлийг тайлагнадаггүй зэрэг дутагдал арилахгүй байгаа нь Улсын Их Хурал бодитой бүрэн мэдээлэлд тулгуурлан бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавих хуулийн заалт бүрэн хэрэгжихгүй байна.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Хянан шалгах түр хороод байгуулагдан хуульд заасан хяналт шалгалтыг явуулж, хоёр түр хороо нотлох баримтыг шинжлэх судлах сонсголыг явуулж, тайлангаа тавьж, татан буугдсан. Түр хороо үйл ажиллагаагаа явуулах явцад эрх зүйн зохицуулалтыг сайжруулах, гэрчийг дуудах, хянан шалгач, шинжээч нарт тавигдах шаардлага бүрэн зохицуулагдаагүй, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг хуульчилсан боловч процессын ажиллагааг журамлаагүйгээс хариуцлага тооцох заалтын хэрэгжилт хангалтгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний стратегийн зорилтыг бүрэн хангуулах, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийн хэрэгжилтийн шатанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, зөрчил, давхардал, хийдлийг арилгах чиглэлээр хуулийн төслийг шинэчилсэн найруулгаар боловсруулах практик хэрэгцээ шаардлага үүссэн.

Хоёр. Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл нь 8 бүлэг, 58 зүйлтэй.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаанд тулгуурлан Монгол Улсын Их Хурлын 2019-2024 стратеги зорилтын хүрээд дэвшиүүлсэн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг гүнзгийрүүлэх, ханган биелүүлэхэд энэ удаагийн эрх зүйн шинэчлэлийн зорилго чиглэгдэнэ. Үүнд хууль

тогтоомжийн биелэлтийг хангуулах, төсвийн хяналтыг өргөжүүлэх, Улсын Их Хурлын гишүүд асуулт, асуулга тавих, Ерөнхий сайдын мэдээлэл сонсох ажиллагааг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх, хуулийг хэрэгжүүлэх шатанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх чиглэлээр эрх зүйн орчинг сайжруулах зэрэг асуудлыг хамарна.

Үүнд:

1.Улсын Их Хурлын гишүүдийн тооны өөрчлөлт, сонгуулийн холимог тогтолцоотой холбоотой дараах өөрчлөлтүүдийг тусгана:

1/Парламентын ардчиллыг бэхжүүлэх, хүчтэй сөрөг хүчнийг бүрдүүлэхэд тэдгээрийн хяналт шалгалтын эрх хэмжээг нэмэгдүүлэн, цөөнхийн бүлэг төсвийн хяналтын сонсголыг санаачлах, Төсвийн зарлагын хяналтын хороо төсвийн хяналт сонсгол явуулсан тайлан, санал дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд шууд танилцуулах боломжтой болно.

2/Улсын Их Хурлын гишүүдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой ерөнхий хяналтын сонсгол хийх, томилгооны, төсвийн, нэр дэвшигчийн сонсгол явуулах хүсэлт гаргах гишүүдийн тоог 15, Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг 7-31 хүртэлх гишүүдтэй байна. Ингэхдээ нийт гишүүдэд эзлэх хэмжээтэй хувь тэнцүүлэн тоог өөрчилнө.

2.Хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, Засгийн газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудууд тавих хяналтыг сайжруулах, хууль, тогтоолоор үүрэг чиглэл өгсөн Улсын Их Хурлын шийдвэрийн биелэлтийг тогтмол сонсож хэлэлцдэг болно. Улсын Их Хурлаас хийх үр дагаврын үнэлгээний тайланг үр дүнтэй хэлэлцэх, Засгийн газрын нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актыг шаардлагатай тохиолдолд хянан үзэх, хүчингүй болгох, хариуцлага тооцох зэрэг өөрчлөлтийг тусгана. Улсын Их Хурлаас байгуулагддаг ажлын хэсгийн үйл ажиллагааг чанаржуулах, эрчимжүүлэх, үр нөлөөг нэмэгдүүлэхтэй холбоотой ажлын хэсэг байгуулахад тавигддаг шаардлагыг нэмэгдүүлэх, явц байдал, үр дүнг холбогдох Байнгын хороо сонсож, ажлын хэсгийг ажлын үр дүнг харгалзан татан буулгах, эсхүл үргэлжлүүлэн ажиллуулах эсэхийг шийдвэрлэдэг болно.

3.Улсын Их Хурлын хяналт шалгалтын төлөвлөлтийг бодитой болгон, Улсын Их Хурлын хяналт шалгалтын цаглаварыг тогтоолоор батална.

4.Улсын Их Хурлын гишүүд асуулт, асуулга, түүний хариуг Байнгын хороонд танилцуулдаг байх, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол нэгдсэн чуулганд танилцуулна.

5.Улсын Их Хурлын төсвийн хяналт, шалгалтыг өргөжүүлэн, төсвийн боловсруулалтын үе шатанд тавих хяналтыг бий болгох, үүнд Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн суурь тооцоо таамаглалыг боловсруулж, эрх бүхий байгууллагад хүргүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн санал нь баталсан төсвийн хязгаарт нийцэж байгаа эсэх, олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан саналыг тусгасан эсэхэд хяналт тавих, төсвийн гүйцэтгэлийн явцын тайланг шаардлагатай гэж үзвэл сонсон хэлэлцэх дэгийг нарийвчлан зохицуулна.

6. Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд иргэний нийгмийн болон төрийн хяналт шалгалтын байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааны уялдааг сайжруулахад чиглэсэн зарим өөрчлөлтийг хийнэ.

Үүнд:

1/Төрийн аудитын байгууллага, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Хүний эрхийн үндэсний комисс зэрэг байгууллагууд Байнгын хорооны даалгаснаар Улсын Их Хурлын хянан шалгалтыг явуулна.

2/Улсын Их Хурлаас хийгдэх тусгай мэдлэг ур чадвар шаардсан хяналт шалгалт, үнэлгээ, дүн шинжилгээ хийхэд хөндлөнгийн хараат бус байгууллага мэргэшсэн шинжээчдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн эрх зүйн байдлыг тодорхой болгоно.

7.Хянан шалгах түр хорооны эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, хууль хэрэгжүүлэх шатанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэнэ. Үүнд:

1/Түр хороог байгуулах, татан буулгах асуудлыг Монгол Улсын Их Хурлын тухай хуульд зааснаар шийдвэрлэнэ. Түр хорооны гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй байх шаардлага, Түр хорооны даргын эрх, үүргийг тодотгон заана.

2/Хянан шалгагч, шинжээч нарын эрх зүйн байдлыг тодорхой болгох, тавигдах шаардлагыг нэмэгдүүлэх, ашиг сонирхлын зөрчилгүй талаарх мэдэгдлийг болон нууц хадгалах баталгаа гаргуулах зэрэг өөрчлөлтийг тусгана.

3/ Гэрч дуудах зохицуулалтыг сайжруулна. Гэрчийн нэрсийг гаргах, танилцуулах хугацааг тодорхойлон, мэдэгдэх хуудсыг хүргүүлэх хэлбэр, хүндэтгэн үзэх шалтгааныг тодорхойлно. Тамгын газар мэдэгдэх хуудсыг гэрчид биечлэн, эсхүл гар утас, цахим хаягаар нь дамжуулан хүргэдэг хэдий ч гэрч түүнийг хүлээн аваагүй, мэдээгүй гэж сонсголд хүрэлцэн ирээгүй шалтгаанаа тайлбарладаг. Олон тооны гэрчийг богино хугацаанд дуудахад Тамгын газрын одоо байгаа хүний нөөцөөр хүргэхэд бодитой хүндрэл гарч байгааг харгалзан мэдэгдэх хуудсыг хүргүүлэх ажлыг Тамгын газар зохион байгуулах, шаардлагатай бол холбогдох төрийн байгууллагаас дэмжлэг авахаар заана.

8.Тамгын газрын чиг үүрэгт зарим өөрчлөлт оруулна:

1/Тусгай мэдлэг ур чадвар шаардсан тайланд дүн шинжилгээ хийлгэхэд хөндлөнгийн хараат бус судлаачдын оролцоог нэмэгдүүлэхтэй холбоотой зарим Тамгын газрын чиг үүргийг шилжүүлнэ.

2/Бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийн тайланг өргөн мэдуулэхээс өмнө хуульд заасан шаардлагыг хангуулах, төсвийн боловсруулалт, гүйцэтгэлийн шатанд тавих хяналт, хууль тогтоомжийн биелэлт, үр дагаврын үнэлгээг сонсоход танилцуулга, дүн шинжилгээ гаргах, талаар дүгнэлт гаргах зэрэг үүрэг шинээр нэмэгдэнэ.

3/Хянан шалгах түр хороо ажлын албатай байх ба ажлын алба байгуулах асуудлыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга тухай бүр шийдвэрлэж байна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар:

1.2019, 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлалд нийцсэн, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлнэ.

2.Улсын Их Хурлаас Засгийн газрын үйл ажиллагаа, хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналт үйл ажиллагаа илүү тодорхой, байнгын шинжтэй болно.

3.Улсын Их Хурлын хяналт шалгалтын тогтолцоонд төрийн хяналт шалгалтын байгууллагын татан оролцуулах, хараат бус мэргэжлийн байгууллагын оролцоог нэмэгдүүлснээр Засгийн газрын үйл ажиллагаанд тавих хяналт сайжирна.

4.Хянан шалгах түр хорооны үйл ажиллагаа жигдэрч, үйл ажиллагааны үр нөлөө дээшилнэ.

5.Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавих Улсын Их Хурлын хяналтыг бий болгосноор хууль тогтоомжийн биелэлтийг хангуулахад мэдэгдэхүйц ахиц дэвшил бий болно.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төслийн талаар:

Энэ хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн ба энэ хуультай хамт 2021 онд баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

Үүнд:

1.Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнг тусгасан хэрхэн тусгасан талаар Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн танилцуулгад тусгадаг байх өөрчлөлтийг тусгана.

2.Сонсгол зохион байгуулахтай холбоотой Нийтийн сонсголын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль хоорондын зөрчлийг арилгана. Төсвийн, ерөнхий хяналтын, нэр дэвшигчийн сонсголыг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу явуулахаар нэмэлт, өөрчлөлт оруулна.

3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг гарсан тухай бүр УИХ-ын мэдээллийн санд байршуулах, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн төслийг боловсруулахад Хууль тогтоомжийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлал хамаарахгүй байх нэмэлтийг тусгана.

4.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөлд “Парламентыг үл хүндэтгэх” зөрчлийн хэргийг цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагч харьялан шийдвэрлэж байх нэмэлтийг тусгана.

5.Олон нийтийн радио телевизийн тухай хуульд Үндэсний зөвлөл ажлаа УИХ-д жил бүр тайлагнах заалтыг нэмж тусгана.

ооОоо